



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/193

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Ховд аймгийн Цэцэг сумын Хажинга багийн нутаг дэвсгэрт Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар “Мөнх гийгүүлэгч” ХХК-ийн гүйцэтгэсэн “Худалдаа үйлчилгээний төв”-ийн барилгыг ашиглалтад оруулах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын

дарга: З.Өмиртай (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Ш.Даваадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын, техникийн хяналтын улсын байцаагч)

Б.Эрдэнэцэцэг (Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуйн улсын байцаагч)

О.Отгон-Эрдэнэ (Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч)

Н.Ням-Эрдэнэ (“Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ийн ерөнхий инженер)

Т.Буяндэлгэр (“Мөнх гийгүүлэгч” ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн

дарга : Б.Жамбалдорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилга, хот байгуулалтын хэлтсийн барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)

8400001 0561  
Zah A/193 Och

2. Ховд аймгийн Цэцэг сумын Хажинга багийн нутаг дэвсгэрт “Мөнх гийгүүлэгч” ХХК-ийн гүйцэтгэсэн “Худалдаа үйлчилгээний төв”-ийн барилгыг ажлын тоо хэмжээ, зураг төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг комиссын дарга (З.Өмиртай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Л.ЭНХБАЯР

